

АУС АХЛАХ СУРГУУЛИЙН ЗААГ ХЯЗГААРЫГ ӨӨРЧЛӨН ТОГТООХ ҮЙЛ ЯВЦЫН ТАЛААР

ӨНӨӨГИЙН ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Хамгийн сүүлийн судалгааны дагуу, 2020-21 оны хичээлийн жил гэхэд Вашингтон Ли ахлах сургуулийн сурагчдын тоо 400 гаруй сурагчдаар нэмэгдэх төлөвтэй байна. Төслийн зорилго бол Йорктаун болон Вейкфийлдийн ахлах сургуулиудад 2017 оны 9 дүгээр сард элсэн суралцах 9-р ангийн сурагчдыг аажмаар нүүлгэн шилжүүлж, 2020 оны 9 дүгээр сар гэхэд дурьдсан 3 сургуулийн элсэлтийг тэнцвэртэй болгоход оршино. Энэ асуудлыг шийдэхийн тулд, АУС нь Вашингтон Ли ахлах сургуулиас дурьдсан 2 ахлах сургуулиуд руу нүүлгэн шилжүүлэлт хийх төлөвлөлтийн нэгжүүдийн талаар олон нийтээс санал хүсэлт авахыг оролдож байга юм.

2020 оны элсэлтийн төсөвлөлдөөр үндэслэн зааг хязгаарыг өөрчлөн тогтоох юм. Бид 2022 онд ахлах сургуульд суралцагчдын тоог 1300–р нэмэх тул тэр үед энэ хязгаарыг дахин шинэчлэн өөрчлөх шаардлага гарах болзошгүй.

ЗААГ ХЯЗГААРЫГ ӨӨРЧЛӨН ТОГТООХ

Зааг хязгаарыг өөрчлөн тогтоохдоо АУСийн гурван ахлах сургуулиудын дунд элсэлтийг тэнцвэртэй зохион байгуулах, боломжит болон төлөвлөсөн сургалтын орон зайг илүү сайн ашиглах үүднээс хийж байга юм. Энэ бол муж даяар хамарсан хил заагийн өөрчлөлт биш юм.

СУРАЛЦАГЧДЫН ХУВЬД

Зааг хязгаарыг өөрчлөн тогтоох зөвлөмжүүдээс дурьдвал:

- Ахлах сургуульд аль хэдийн элсэн орсон суралцагчдад хамаарагдахгүй болно.
- 2017 оны 9 дүгээр сараас хэрэгжинэ (ирэх намар)
- Одоогийн 8 дугаар ангийн 100 гаруй сурагчид (2017-2018 оны хичээлийн жилд шинээр элсэн орсон суралцагчид) өөрчлөлт хийх төлөвлөлтийн нэгжид хамрагдана.
- Вашингтон Ли ахлах сургуульд элсэн орогчдын ах, эгч хамт суралцаж байгаа бол шаардлагатай тохиолдолд тэдэнд зориулсан тээврийн хэрэгслийн талаарх заалтуудыг нэмж оруулна
- 2016 оны 12 дугаар сарын 12-ны орой ахлах сургуулийн мэдээлэлд энэ жилийн хамт олон болон эцэг эхчүүдэд мэдээллийг хүргэнэ.

ХЭЛЭЛЦЭЖ БУЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН НЭГЖИЙН ТАЛААР

Хэлэлцэж буй төлөвлөлтийн 51 нэгжүүд нь одоогоор Вашингтон Ли ахлах сургуулийн зааг хязгаарт багтаж байгаа бөгөөд Йорктаун болон Вейкфийлдийн ахлах сургуулиудын зааг хязгаартай зэрэгцэн оршиж байгаа болно. Сургуулийн зөвлөлийн факультетийн зөвлөх хорооны хүсэлтээр цөөн тооны төлөвлөлтийн нэгжүүдийг оруулсан болно. (хавсаргасан зургийг харна уу.)

ОЛОН НИЙТИЙН САНАЛ ХҮСЭЛТ

АУС нь зааг хязгаарыг өөрчлөн тогтоох талаар мэдээллийг гэр бүл болон олон нийтийн гишүүдэд хүргэхэд туслахын тулд “Эхлэл ажил” цуврал олон нийтийн уулзалтуудыг

зохион байгуулах болно. “Эхлэл ажил” уулзалт бүрт нэг төрлийн мэдээллийг хүргэнэ. Уулзалтыг 4 удаа зохион байгуулна. Үүнд:

- 10 дугаар сарын 12-ны өдрийн Лхагва гаригт оройн 7 цагт Вашингтон Ли ахлах сургуулийн цайны газарт (ярилцлагаар)
- 10 дугаар сарын 15-ны өдрийн Бямба гаригт өглөөний 10 цагт Жефферсон дунд сургуулийн номын санд (Испани хэлээр танилцуулна)
- 10 дугаар сарын 17-ны өдрийн Даваа гаригт оройн 7 цагт Йорктаун ахлах сургуулийн цайны газарт
- 10 дугаар сарын 19-ны өдрийн Лхагва гаригт оройн 7 цагт Вейкфийлд ахлах сургуулийн цайны газарт

Зааг хязгаарыг өөрчлөн тогтоох талаар олон нийтийн санал хүсэлт авах цахим зааг хязгаарын аргачлал 10 дугаар сарын 12-24-ны өдрүүдэд бэлэн байна. Мөн цаасаар нэмэлт өөрчлөлт болон санал аа явуулаж болно.

АУС нь 10 дугаар сарын 27-ны өдрийн Пүрэв гаригт оройн 19 цагт олон нийтийн “Бид юу сонсож мэдэв” сэдэвт уулзалтыг зохион байгуулаж, нэмэлт мэдээлэл авах, хүлээн авсан мэдээллээ хуваалцахын тулд Вашингтон Ли сургуулийн цайны газарт ярилцлага зохион байгуулах юм. Энэхүү хэлэлцүүлгээр Сургуулийн зөвлөлөөс авч хэлэлцүүлсэн зөвлөмжүүдийн талаар мэдээлэх юм.

Эдгээр зөвлөмжүүдийг 11 дүгээр сарын 3-ны өдрийн хурлаар Сургуулийн зөвлөлд танилцуулах юм. Зөвлөл 11 дүгээр сарын 9-ний уулзалтаар гарсан зөвлөмжүүдийн талаар авч хэлэлцэх бөгөөд 11 дүгээр сарын 15-ны өдрийн Сургуулийн зөвлөлийн хурлаас гарсан төрийн мэдээллийг сонордуулах юм. Ахлах сургуулийн зааг хязгаарыг өөрчлөн тогтоох эцсийн төлөвлөгөөг 12 дугаар сарын 1-ний өдрийн Пүрэв гаригт 12 дугаар сарын 12-ны өдрийн Даваа гаригийн орой ахлах сургуулийн мэдээллээр хамт олонд танилцуулах болно.

ЦАХИМ ЗААГ ХЯЗГААРЫН АРГАЧЛАЛ

Ахлах сургуулийн зааг хязгаарыг өөрчлөн тогтоох аргачлал нь Арлингтон мужид ахлах сургуулийн зааг хязгаарт зориулан төлөвлөсөн өөрчлөлтийг мэдээлэхэд хамгийн сүүлийн үеийн элсэлтийн мэдээллийн санг ашиглан ажиллах боломжоор АУС-г хангах болно. Өөрчлөлт хийгдэж дууссаны дараа аргачлал хэрхэн хийгдэж, зөвлөмжүүдийг яаж оруулсныг харуулсан цахим видео бэлэн болох юм. Нэмэлт мэдээллийг зааг хязгаарын веб сайтад мөн оруулсан байгаа.

Зааг хязгаарын аргачлалаас олон нийтийн гишүүд явган явах бүсийг харж болох төдийгүй анхан болон дунд сургуулийн зааг хязгаарыг харж, зөвлөмжүүдээ мэдээлэхэд туслах болно. Мөн цаасаар нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Зааг хязгаарыг өөрчлөн тогтоох аргачлалын талаар www.apsva.us/APSboundaries сайтаас 10 дугаар сарын 12-24-ны өдрүүдэд авч болно. Аргачлалтай холбоотой асуулт, тодруулга эсвэл нэмэлт мэдээлэл хэрэгтэй бол apsboundaries@apsva.us. цахим хаягаар бидэнтэй холбогдож болно.

ХОЛБОГДОХ ХАЯГ, УТАС

- Цахим хаяг: apsboundaries@apsva.us
- Утас: 703-228-6310

